



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 301

Улаанбаатар хот

「 Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын
сургуульд суурилсан эрүүл мэндийн урьдчилан
сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг зохион
байгуулах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамруулах товлал, заавар, удирдамжийг тус тус баталж, мөрдүүлэхийг Эрүүл мэндийн сайд Э.Батшугарт даалгасугай.

2.Суралцагчдыг батлагдсан товлалын дагуу үзлэгт бүрэн хамруулах ажлыг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, үзлэгийн дүн, эрсдэлийн үнэлгээнд үндэслэн суралцагчдыг дараагийн шатны үзлэг оношилгоонд шилжүүлэх, өвчин эмгэг илэрсэн тохиолдолд эмчийн хяналтад авах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх зэрэг цогц арга хэмжээг 2026-2027 оны хичээлийн жилээс эхлэн зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Боловсролын сайд Л.Энх-Амгалан нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоог зохион байгуулахад шаардагдах мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн эмч, холбогдох албан тушаалтанд зориулсан чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Боловсролын сайд Л.Энх-Амгалан нарт даалгасугай.

4.Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүртгэлийн сан бүрдүүлж, боловсролын болон эрүүл мэндийн салбарын мэдээллийн цахим систем хооронд өгөгдөл солилцох боломж нөхцөлийг хууль тогтоомжид нийцүүлэн 2027 оны 1 дүгээр улиралд багтаан бүрдүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа, холбооны сайд Ч.Номин, Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Боловсролын сайд Л.Энх-Амгалан нарт тус тус үүрэг болгосугай.

5.Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулахад шаардагдах зардлыг тухайн жилийн батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Боловсролын сайд Л.Энх-Амгалан нарт даалгасугай.

6.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хүүхэд, суралцагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамруулсан тайлан, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүн, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд Э.Батшугар, Боловсролын сайд Л.Энх-Амгалан нарт үүрэг болгосугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.УЧРАЛ

БОЛОВСРОЛЫН САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН